


Ерөнхий боловсролын Шинэ Монгол сургуулийн захирлын 2024 оны 02 сарын 14-ний өдрийн А/14 дугаар тушаалын хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛИЙН НЭГДҮГЭЭР АНГИД СУРАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2024-2025 оны хичээлийн жилд тус сургуулийн нэгдүгээр ангийн элсэлтийг зохион байгуулах явцад үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- Нэгдүгээр ангид сурагч элсүүлэхэд сургуулийн дүрэм, дотоод журам болон энэхүү журмыг баримтална.
- БСШУ-ын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/200 тоот тушаалыг үндэслэн 1-р ангийн элсэлтийг “Зургаан настай хүүхдээс аливаа шалгалт, сорил авахгүй” бөгөөд эцэг эх, хүүхэд, сургуулийн “Хамтарсан уулзалт ярилцлага” хийж, 1-р ангид сурагч элсүүлнэ.
“Хамтарсан уулзалт” ярилцлагыг хөндлөнгийн комиссын боловсруулсан үнэлгээний аргачлалын дагуу дүгнэнэ.
- “Хамтарсан уулзалт ярилцлага”-д оролцох хүмүүс зөвхөн монгол хэлээр харилцана.
- “Хамтарсан уулзалт” ярилцлагын үр дүнгээр 72 хүүхдийг элсүүлнэ.
- “Хамтарсан уулзалт ярилцлага”-д дараах байдлаар оролцоно. Үүнд:
 - Хамтарсан уулзалт ярилцлагад 6 настай хүүхэд өөрөө оролцоно.
 - 6 настай хүүхдээс гадна насанд хүрсэн хоёроос илүүгүй хүн оролцоно.
 - Насанд хүрсэн 2 хүн нь 6 настай хүүхдийн эцэг эх байна.
 - Хүндэтгэн үзэх шалтгаантай нөхцөлд эцэг эхийн аль нэг дангаар, эсхүл эцэг эхийг төлөөлсөн хүүхдийн асран хамгаалагч орж болно.
 - Бүртгүүлэх үед “Хамтарсан уулзалт ярилцлага”-д хүүхдийн хамт оролцох насанд хүрсэн 2 хүнээ сонгож бүртгүүлэх бөгөөд тухайн бүртгүүлсэн хүмүүс “Хамтарсан уулзалт” ярилцлагад орно.

ХОЁР. БҮРТГЭЛ

- Бүртгэл цахимаар явагдана.
- Бүртгэлийн хугацаа:
2024 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 09:00 цагаас 03 дугаар сарын 13-ны өдрийн 16:00 цаг хүртэл <http://admission.shinemongol.edu.mn/> хаягаар орж бүртгүүлнэ.
- Бүртгүүлэхэд анхаарах зүйлс:
 - Бүртгүүлэгч нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд төрсөн байх;
 - Бүртгүүлэгчийн овог нэрийг крилл үсгээр бичиж, регистрийн дугаарыг алдаагүй зөв оруулах;
 - Хүүхдийн цээж зургийг системд оруулахдаа сүүлийн 3 сард авхуулсан зургийг зөвхөн регистрийн дугаараар нь хадгалах; /зургийн файлын төрөл нь jpeg, png, jpg өргөтгөлтэй байх/
 - Бүртгүүлэгчийн эцэг, эх асран хамгаалагч нь өөрийн и-мэйл хаяг, холбоо барих утасны дугаарыг заавал бичих;
 - Бүртгүүлэгчийн эцэг эх, асран хамгаалагч нь доорх асуулт **бүрд** дэлгэрэнгүй хариулан бичиж **word** эсвэл **pdf** файлаар оруулах; /Асуултын хариултыг оноогоор дүгнэхгүй ба сургуульд хүүхдээ оруулах хүсэлтэй эсэхийг харгалзах үүднээс хүлээн авна/

Асуулт:

① *Та хүүхдийнхээ зан төлөвшил, авьяас чадварын онцлогийг бичнэ үү. Хүүхдийн тань эдгээр онцлогт танай гэр бүлийн ямар үнэт зүйл, хүмүүжлийн арга барил нөлөөлсөн гэж үзэж байна вэ?*

② *Та Шинэ Монгол сургуулийн юуг нь онцолж, сонгох болсон бэ?*

е. Бүртгэлийн явцад бүртгэлийн хураамж 40000 /дөчин мянга/ төгрөгийг төлөх тул дараах бэлтгэлийг хангаж бүртгэлийн системд хандана уу.

ё. Бүртгэлийн хураамж төлөх зааврыг бүртгэлийн нүүр хуудаснаас үзнэ.

- Бүртгэлийн хураамжийг [/admission.shinemongol.edu.mn/](http://admission.shinemongol.edu.mn/) хаягаар орж **QPAY** үйлчилгээ ашиглан **QR** код уншуулан бүх банкны аппликейшн ашиглан төлнө.
- Бүртгүүлэгчтэй ярилцлагад хамт оролцох хүмүүсийн талаар бүртгэлийн системд тохирох сонголтыг хийнэ.

ж. Бүртгүүлэгчийн регистрийн дугаараар цахим бүртгэлд нэг л удаа бүртгүүлэх боломжтойг эцэг эх, асран хамгаалагч анхаарна уу. /Регистрийн дугаарыг үнэн зөв, алдаагүй, криллээр бичих бөгөөд алдаатай бичсэн тохиолдолд бүртгэл хүчингүйд тооцогдоно./

з. Ерөнхий боловсролын “Шинэ Монгол” сургууль эсвэл “Шинэ Монгол Харүмафүжи” сургуулийн зөвхөн нэгийг сонгож бүртгүүлнэ. Давхар бүртгүүлсэн тохиолдолд, шүүж аль сүүлд бүртгүүлснээр бүртгэх тул анхаарна уу. Хоёр сургуулийн бүртгэл зэрэг эхэлж, ярилцлага зэрэг явагдана.

и. Бүртгэл амжилттай болсноор бүртгүүлэгч цахим бүртгэлийн системд нэвтэрч ярилцлагатай холбоотой аливаа мэдээллийг шуурхай авах эрх үүснэ.

4. Бүртгүүлэгч нь цахим бүртгэл хаагдсаны дараа буюу 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 09:00 цагаас хойш дараах мэдээллийг бүртгэлийн хуудаснаас харах боломж нээгдэнэ.

- Бүртгэлийн дугаар
- Бүртгүүлэгчийн эцэг эхэд зориулсан “Хамтарсан уулзалт”-ын талаар чиглүүлэг өгөх цахим уулзалтын цагийн хуваарь
- “Хамтарсан уулзалт” ярилцлагад орох цагийн хуваарь
- Уулзалт, ярилцлагын холбоосууд

ГУРАВ. “ХАМТАРСАН УУЛЗАЛТ” ЯРИЛЦЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. “Хамтарсан уулзалт”-ын талаар чиглүүлэг өгөх цахим уулзалтыг 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулна.

2. “Хамтарсан уулзалт” ярилцлагыг сургууль дараах байдлаар зохион байгуулна.

а. “Хамтарсан уулзалт” ярилцлагыг 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулна.

б. “Хамтарсан уулзалт” ярилцлагыг “ZOOM” аппликейшн ашиглан цахимаар явуулна.

в. “Хамтарсан уулзалт” ярилцлагын үргэлжлэх хугацаа нэг хүүхдэд 15 минут онооно.

г. “Хамтарсан уулзалт” ярилцлагыг хөндлөнгийн комисс бүрдүүлж зохион байгуулах ба тэдний боловсруулсан үнэлгээний аргачлалын дагуу дүгнэнэ.

3. Эцэг эхийн зүгээс ярилцлагад оролцоход анхаарах зүйлс:

а. Ярилцлагын хуваарийн дагуу холбоосоор хоцрохгүй орж, ерөнхий мэдээллийг нягтлан, техник хэрэгслийн бэлэн байдлыг шалган, туршиж үзсэн байх

б. Ярилцлагын үеийн техникийн /компьютер, камер, чихэвч, микрофон, интернэтийн хурд/ саадгүй ажиллагааг бүрэн хангах, урьдчилан “ZOOM” аппликейшн татаж суулгасан байх;

в. Ярилцлагын үед орчны дуу чимээг хязгаарласан байх;

г. Чиглүүлэгч багш, ажилтны шаардлага, зөвлөгөөг хүндэтгэн мөрдөх;

д. “Хамтарсан уулзалт” ярилцлагын явцад зөвшөөрөлгүй бичлэг хийх, зураг авах, өөрсдийн ярилцлагын талаар үндэслэлгүй ташаа мэдээлэл цахим хуудсаар тараах, сургуулийн нэр хүндэд халдах, багш ажилтныг хэл амаар доромжлох, харилцаа, хандлагын зохисгүй байдал гаргахгүй байх;

4. “Хамтарсан уулзалт” ярилцлагын дүнг мэдээлэх:

2024 оны 03 дүгээр сарын 18-ны өдрийн 09:00 цагт гаргаж бүртгүүлэгчийн бүртгэлийн хуудсанд элсэх эрх олгосон эсэх тухай мэдээллийг илгээн, сургуулийн www.shinemongol.edu.mn хаяг болон “Шинэ Монгол сургууль” фэйсбүүк хуудсанд нэгдсэн мэдээг байршуулна.

5. Элсэн суралцах батламж гардуулах:

“Хамтарсан уулзалт” ярилцлагын дүнд элсэх эрх авсан элсэгчдэд батламж гардуулна. Элсэгч 2024 оны 03-р сарын 18-ны өдрийн 11:00-18:00 цагт урьдчилан өгсөн хуваарийн дагуу эцэг, эх асран хамгаалагчдын хамтаар сургуулийн байранд хүрэлцэн ирнэ.

ДӨРӨВ. БУСАД

1. Цахим бүртгэл болон “Хамтарсан уулзалт” ярилцлагын үеэр үүсэх аливаа асуудал, санал гомдлыг сургууль бие даан шийдвэрлэнэ.
2. “Хамтарсан уулзалт” ярилцлагын үед ярилцсан агуулгыг задруулахгүй байхад сургуулийн зүгээс болон эцэг эхийн зүгээс анхаарна.
3. Сургуулийн зүгээс үүссэн техникийн аливаа саатлыг богино хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэнэ.
4. Цахим бүртгэлтэй холбоотой яаралтай асуух зүйлээ **80280591** дугаарт холбогдож мэргэжлийн зөвлөгөөг 10:00-17:00 цагийн хооронд авч болно.
5. “Хамтарсан уулзалт” ярилцлагатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг **80287052** дугаараас 10:00-17:00 цагийн хооронд холбогдож лавлагаа авч болно.
6. “Хамтарсан уулзалт” ярилцлагын талаарх санал хүсэлтийг 03-р сарын 18-ны өдрийн 16:00 цаг хүртэл school@shinemongol.edu.mn хаягаар хүлээн авна.
7. **Сургууль танилцуулах өдөрлөгийг 2024оны 03-р сарын 02-ны өдөр 10:00-17:00 цагийн хооронд зохион байгуулна.**

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛЬ